

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.030.99

Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Үйлдвэрийн хаягдал бохирдлын цаг уурын холбогдолтой үндсэн нэр, томьёо тодорхойлолт	MNS 17.2.1.17:80
Охрана природы. Атмосфера . Метеорологические аспекты загрязнения и промышленные выбросы. Основные термины определения.	ГОСТ 17.2.1.04-77

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Үнэ, стандартын улсын хорооны 1980 он 221 дүгээр тогтоолын дагуу 1981 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Стандартыг зөрчвөл хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Энэ стандарт агаар мандлыг үйлдвэрийн бохирдлоос хамгаалах, агаар мандлын бохирдлын цаг уурын асуудлын талаар шинжлэх ухаан, техникийн үйлдвэрлэлд хэрэглэх нэр томьёо, тодорхойлолтын үндсэн ойлголтуудыг тогтооно.

Энэ стандартаар тогтоосон нэр томьёог улс ардын аж ахуйд хэрэглэж буй бүх төрлийн баримт бичиг, шинжлэх ухаан техник, сургалтын болон лавлах ном хэвлэлд албан ёсоор хэрэглэвэл зохино.

Ойлголт бүрд стандартчилсан нэг нэр томьёо тогтоосон болно. Зайлшгүй тохиолдолд стандартад заасан ойлголголтын утгыг гажуудуулахгүй тодорхойлолтын хэлбэрийг өөрчилж болно.

Стандарт нэр томьёоны оронд ижил утгатай нэр томьёог хэрэглэхийг хориглоно. Стандарт нэр томьёог орлуулан хэрэглэж болохгүй ижил утгатай нэр томьёог "ОХБ" үсгээр тэмдэглэсэн болно. Стандартад лавлах мэдээллийн журмаар стандарт нэр томьёог орос хэл дээр хадаж өгсөн байна.

Ойлголтын гол шинж чанарыг нэр томьёо нь шууд илэрхийлж буй тохиолдолд "тодорхойлолт" гэсэн баганад зураас (-) тавьж тэмдэглэсэн болно.

Хүснэгт

Нэр томьёо	Тодорхойлолт
1. Хольцын эх үүсвэр Источник примеси 2. Агаар мандал дахь хольц Примесь в атмосфере	- Агаар мандалд тархсан, түүний тогтмол найрлагад байдаггүй бодис

1	2
<p>3. Агаар мандалд дахь хольцын зөвшөөрөгдөх дээд концентраци Предельно допустимая концентрация примеси в атмосфере</p> <p>ОХБ боломжит хамгийн их агууламж Максимально возможная концентрация</p> <p>4. Агаар мандлын бохирдол Загрязнение атмосферы</p> <p>5. Агаар мандлын антропоген бохирдол Антропогенное загрязнение атмосферы</p> <p>6. Агаар мандлын байгалийн бохирдол Естественное загрязнение атмосферы</p> <p>7. Агаар мандлын бохирдлын цаг уурын хүчин зүйлс Метеорологические факторы загрязнения атмосферы</p> <p>8. Агаар мандлын бохирдлын потенциал (чадавхи) Потенциал загрязнения атмосферы</p>	<p>Тодорхой нэгэн дундач хугацаанд агаар мандалд байх хольцын, үргэлжийн биш үйлчилгээнд буюу хүний бүхий л амьдралын турш түүнд болон хүрээлэн байгаа орчинд бүхэлд нь алслагдсан үр дагаварыг оролцуулан ямар нэгэн хорт үйлчлэл үзүүлэхгүй байх хамгийн их концентраци</p> <p>Агаар мандалд хольц ихссэнээс түүний найрлага өөрчлөгдөх Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр агаар мандал бохирдох</p> <p>Байгалийн процессоос шалтгаалан агаар мандал бохирдох</p> <p>Агаар мандлын бохирдолд нөлөөлөх цаг уурын элемент, үзэгдэл, процесс</p> <p>Газар үйн тухайн мужид орших эх үүсвэрүүдээс агаарын бохирдох боломжит түвшинг нөхцөлдүүлэх цаг уурын хүчин зүйлсийн хамсал</p>
<p>9. Салхины аюултай хурд Опасная скорость ветра</p> <p>10. Дулааны арал Остров тепла</p> <p>11. Хорт манан Смог</p> <p>12. Фото-химийн хорт манан Фото химический смог</p> <p>13. Агаар мандлын нэвчил Атмосферная диффузия ОХБ. Хуйлралын нэвчил</p>	<p>Эх үүсвэрээс гарсан хольцын концентраци газар орчим хамгийн их байх үед тогтоосон, өндөр дэх салхины хурд</p> <p>Хотын гаднах агаараас илүү температур бүхий агаартай, хот дахь район</p> <p>Хийн болон хатуу хольцууд, манан, тоосонцорын униартай нэгдсэн хувирч агаар мандал эрчимтэй бохирдох үзэгдэл</p> <p>Нарны цацрагийн үйлчлэлээр агаар мандалд дахь хольцуудын хооронд явагдсан урвалын дүнд бий болох хорт манан</p> <p>Агаар мандлын турбулент чанарыг нөхцөлдүүлэх агаар ба түүний доторх хольцын эмх замбараатай</p>

<p>Вихревая диффузия 14. Агаар мандлын турбулент нэвчлийн итгэлцүүр Коэффициент турбулентной диффузий в атмосфере</p> <p>15. Агаар мандал аяндаа цэвэрших Самоочищение атмосферы</p> <p>16. Агаар мандлаас хольц замхрах Вымывание примеси из атмосферы</p> <p>17. Агаар мандлаас хольц унах Выпадение примеси из атмосферы</p>	<p>холилдол Агаар мандал дахь хольцын дундаж турбулент урсгал ба түүний дундчилсан концентрацтай шатлалын хоорондын хэмнэг чанарын итгэлцүүр Байгалийн хувьсал, явцын нөлөөгөөр хорт хольцыг зайлуулсны үр дүнд агаар мандлын байгалийн бүрэлдэхүүн бүрэн буюу хэсэг-чилсэн сэргэн тогтох Үүл, манан үүсэх, түнадас орох, агаар мандлаас хольц замхрах Гравитацын хүчний нөлөөгөөр агаар мандлаас хольц зайлуулагдалт</p>
<p>18. Бодисын хаягдал Выброс вещества 19. Хаягдлын чадал (цацах чадал) мощность выброса 20. Хорт бодисын хаягдлын зөвшөөрөгдөх хэмжээ Предельно допустимый выброс (ПДВ)</p> <p>21. Хаягдлын бүртгэл тооцоо Инвентаризация выбросов</p> <p>22. Агаар бохирдуулагч бодис Загрязняющие воздух вещества</p> <p>23. Агаар мандлыг хамгаалах Охрана атмосферы 24. Агаар мандлын үйлдвэрийн гаралтай бохирдлын эх үүсвэр Промышленный источник загрязнения атмосферы 26. Үйлдвэрийн хаягдал Промышленный выброс 27. Үйлдвэрийн эмх цэгцтэй хаягдал Организованный промышленный выброс</p>	<p>Хольцын эх үүсвэрээс агаар мандалд цацагдаж буй бодис Нэгж хугацаанд агаар мандалд хаягдаж буй бодисын тоо, хэмжээ Газар орчмын агаарын давхарга дахь бохирдуулах бодисууд, дангаараа буюу нийлмэл байдлаараа хүн ам, амьтан ба ургамлын аймгийн хэрэгцээт агаарын чанарыг бууруулахгүй байхаар тогтоосон шинжлэх ухаан техникийн норматив Хаягдлын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хольцын эх үүсвэрийг нутаг дэвсгэрээр хуваарилан байрлуулалтын тухай системчилсэн мэдээ бүртгэл Хүн амын эрүүл, мэнд, хүрээлэн буй орчинд зохисгүй нөлөөлөх агаар мандал дахь хольц - Хий, утаа, агаар сорох, татах тусгай байгууламж болон яндангаар агаар мандалд цацаж буй аж үйлдвэрийн хаягдал</p>

1	2
<p>28. Үйлдвэрийн цэгцгүй хаягдал Неорганизованный промышленный выброс</p> <p>29. Үйлдвэрлэлийн хаягдлын химийн бүрэлдэхүүн Химический состав промышленного выброса</p> <p>30. Хийг цэвэрлэх Очистка газа</p> <p>31. Хийг үйлдвэрийн аргаар цэвэрлэх Промышленная очистка газа</p> <p>32. Хийн ариун цэврийн цэвэрлэгээ Санитарная очистка газа</p> <p>33. Утаат хий Дымовой газ</p> <p>34. Цэвэрлэгээгүй хий Неочищенный газ</p> <p>35. Цэвэрлэгдсэн хий Очищенный газ</p> <p>36. Үйлдвэрлэлийн тоос Промышленная пыль</p>	<p>Багаж төхөөрөмжийн бин битүү байдал алдагдсан буюу утаа, хий, сорох төхөөрөмжгүй, эсвэл тэдгээрийн найдваргүй ажилласнаас болж агаар мандалд эмх замбараагүй гарч буй үйлдвэрийн хаягдал</p> <p>Аж үйлдвэрийн гаралтай бохирдлын эх үүсвэрээс агаар мандалд оруулж буй бохирдуулах бодисыг ялгах, хоргүй болгож хувиргах ажиллагаа Дахин ашиглах буюу ялган ангилах зорилгоор үйлдвэрлэлийн аргаар хийг хольцоос цэвэрлэх ажиллагаа Үйлдвэрлэлийн байр, хот суурин газрын агаарт бохирдуулагч бодис зөвшөөрөгдөх концентрацыг хангаж чадахуйц хэмжээнд хорт бодисоос цэвэрлэх ажиллагаа Органик бодис шатахад аж үйлдвэрийн гаралтай эх үүсвэрээс ялгарах хий</p> <p>Хий цэвэрлэх нэг болон хэд хэдэн аппаратуудыг дамжин цэвэрлэгдсэн хий Үйлдвэрлэлийн хаягдлын бүтцэд багтах тоос</p>
<p>37. Тоосны цацдасын (дисперийн) бүрэлдэхүүн</p> <p>38. Хий тоосжих Запыленность газа</p> <p>39. Хийн цэвэрлэгээний зэрэг Степень очистки газа</p> <p>ОХБ. Хийн цэвэрлэгээний итгэлцүүр Коэффициент очистки газа</p>	<p>Функцийн параметр буюу тоосны ширхэгийн харьцангуй агуулгаар илэрхийлэгдэх тоосны хэсгийг ширхэгийн хэмжээгээр нь хуваарилсан бүрэлдэхүүн Хийн доторх тоосны нийт концентраци Цэвэрлэсний дараа хийн дотор агуулагдаж байсан бохирдуулах бодисын массыг (цулыг) цэвэрлэхийн өмнөх масс (цул) -д харьцуулсан харьцаа</p>

ТӨГСӨВ.